



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/192


Мөрөн

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-гийн "а", аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.7, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 13 дугаар зүйлийн 13.1 дахь заалт, аймгийн ИТХ-ын 2014 оны 8 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох аж ахуйн нэгжүүдийн нэр, талбайн хэмжээ, байршил, солбилцлыг хавсралт ёсоор баталсугай.
2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Даваахүү/, аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга Р.Жаргалсайхан, холбогдох сумдын Засаг дарга нарт даалгасугай.
3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбайг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга /Х.Ган-Очир/, аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Ганзориг/ нарт даалгасугай.
4. Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг аймаг орон нутгийн орлогот төвлөрүүлж, тооцон ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/-д үүрэг болгосугай.
5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга /Г.Төмөрбаатар/-т үүрэг болгосугай.

ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР

Аймгийн Засаг даргын 2015 оны
05 дугаар сарын 20-ны өдрийн
А/192 дугаар захирамжийн хавсралт

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН
ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН
НЭГЖҮҮДИЙН ТАЛБАЙ

№	Аж ахуйн нэгжийн нэр, Регистрийн дугаар	Сум, талбайн нэр	Талбайн хэмжээ га	Солбилцол
1	Эгийн-Өлгий ХХК /4135423/	Мөрөн- Нисэхийн ард	66,2	100-4-12,43 49-40-44,36 100-4-58,28 49-41-15,33 100-4-58,28 49-40-36,76 100-4-12,43 49-40-36,76
2	Хөвсгөл Геологи ХК /2034441/	Түнэл – Нам давааны өвөр	27,37	100-9-5,52 49-44-5 100-9-30 49-44-5 100-9-30 49-43-46,92 100-9-5,52 49-43-46,92

_____ ооо _____